

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2014 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРСЭН ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ЧАНАРЫН БОЛОН ТОО ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	Хэрэгжүүлсэн хөтөлбөрийн		Хэрэгжүүлсэн хөтөлбөрийн		Нэмэлт тайлбар
		2014 оны зорилгот түвшин	2014 онд хүрсэн түвшин	2014 оны төсөв	2014 оны гүйцэтгэл	
2	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА					
2.1	Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих					
2.1.1	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан	хуульд заасан хугацаанд хуралдсан байх	хуульд заасан хугацаанд хуралдсан	12,827,528.5	11,623,774.7	Улсын Их Хурлын чуулган Улсын Их Хурлын тухай хуулийн 15.1-т заасан хугацаанд хуралдсан. 2013 намрын ээлжит чуулган /2014.01.09-2014.01.30/ 2014 оны хаврын ээлжит чуулган /2014-04.07-2014.07.01/ Хүндэтгэлийн чуулган /2014.08.22/ 2014 оны намрын ээлжит чуулган 2014.10.01-2014.12.31 -ний хугацаанд тус тус хуралдсан.
2.1.2	Чуулганаар хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлыг хэлэлцүүлэх хувь	85	87.2	211,264.8	207,064.7	Улсын Их Хурлын намрын чуулганаар 17 асуудал, хаврын чуулганаар 22 асуудал нийт 39 асуудал 2014 онд хэлэлцэхээр төлөвлөсөн Намрын чуулганаар 17 асуудал, хаврын чуулганаар мөн 17 асуудал нийт 34 асуудал хэлэлцэж зорилтот түвшинг хангасан.
2.1.3	Чуулганаар хэлэлцсэн асуудлыг шийдвэрлэх хувь	100	100	1,223,635.3	1,164,716.5	Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцсэн 34 асуудлыг 100 хувь шийдвэрлэв. 2014 онд бие даасан хууль 21, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 110, хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль 12, зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хууль 12, Улсын Их Хурлын тогтоол 78 -ыг тус тус батлав.
2.1.4	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой тайлан, мэдээллийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх тоо	4-өөс доошгүй удаа	14 удаа	1,244,877.5	1,098,134.8	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Улс орны эдийн засаг, нийгэм, санхүү төсвийн талаар чуулганы хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын 8 удаагийн мэдээллийг хэлэлцэж давхардсан тоогоор 105 гишүүн 289 асуулт тавьж, харуулт авав. 2014 онд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 24 гишүүн 59 асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон Монголбанкны Ерөнхийлөгчид хандан 19 удаагийн асуулга тавьж 6 асуулгын хариуг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар сонсож Улсын Их Хурлын 30 гишүүн 87асуулт тавьж санал бодлоо илэрхийлэв.

<p>Хууль, Улсын Их Хуралд бусад шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн болон Улсын Их Хуралд үйл ажиллагаагаа тайлагнадаг байгууллагын тайланг Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх</p> <p>2.1.5</p>	<p>байгууллага тус бүрд 1-ээс доошгүй удаа</p>	<p>байгууллага тус бүрд 1-ээс доошгүй удаа</p>	<p>3,629,813.4</p>	<p>1,567,930.8</p>	<p>Хууль, Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллав. Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Засгийн газарт болон Засгийн газрын гишүүдэд 132 хуулийн 407 заалтаар үүрэг өгснөөс давхардсан тоогоор 114 хуулийн 302 заалт буюу 74.2 хувь хэрэгжиж, 24 хуулийн 51 заалт буюу 12.5 хувь хэрэгжих шатанд, 33 хуулийн 54 заалт буюу 13.3 хувь хэрэгжээгүй байна.</p> <p>Улсын Их Хурлын 81 тогтоолын 263 заалтыг хяналтад авч ажиллав. Үүнээс 45 тогтоолын 115 заалт буюу 43.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 79 тогтоолын 124 заалт буюу 47.1 хувь нь хэрэгжих шатанд, 7 тогтоолын 21 заалт буюу 8.0 хувь нь хэрэгжилтийн хугацаа болоогүй, 2 тогтоолын 3 заалт буюу 1.1 хувь нь тасарсан байна.</p> <p>Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, илтгэл, мэдээллийг хуульд заасан хугацаанд Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцэж тодорхой чиглэл өгөв.</p>
<p>2.2</p>	<p>Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх</p>				
<p>Улсын Их Хурлын бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцлийг хангах</p> <p>2.2.1</p>	<p>Хуульд заасны дагуу хангагдсан байх</p>	<p>Хуульд заасны дагуу хангагдсан</p>	<p>5,526,558.00</p>	<p>3,951,834.70</p>	<p>2014 онд нийт 155 хууль, Улсын Их Хурлын 78 тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэн, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, бие даасан хууль 21, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 110, хууль хүчингүй болсонд тооцох тухай 12 хууль, зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай 12 хууль, Улсын Их Хурлын 78 тогтоолыг тус тус батлуулж, эцсийн найруулгыг хийж, ёсчуулав. Улсын Их Хурлын Байнгын хороодын 206 удаагийн хуралдааны бэлтгэл зохион байгуулалтыг ханган ажиллаж, 161 хууль, 88 тогтоолын төсөл, 18 хяналт шалгалтын тайлан, Байнгын хорооны 16 төлөвлөгөө, түүний биелэлтийг хэлэлцэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлээ.</p> <p>Байнгын хорооны 89 тогтоолыг баталж, хэлэлцэх эсэхийн 129 санал, дүгнэлт, анхны хэлэлцүүлгийн 116 санал, дүгнэлт, Байнгын хорооны 36 танилцуулга, 1461 зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг бэлтгэн чуулганы нэгдсэн хуралдаанд оруулан хэлэлцүүлж шийдвэрлүүлэв.</p> <p>Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын, дэд хороодын хуралдааныг хэвийн явуулах нөхцөл бүрдүүлэн хуралдааны тэмдэглэлийг цаг тухайд нь гаргаж албажуулан ажиллав. Улсын Их Хурлын чуулганы 72 удаагийн нэгдсэн хуралдаан, Байнгын хороодын 222, дэд хороодын 9 удаагийн хуралдааныг хэвийн явуулах бэлтгэлийг хангаж ажиллав.</p> <p>Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны явцын талаар 650 хуудас гар тэмдэглэл хөтөлж, 5212 хуудас дэлгэрэнгүй тэмдэглэлийг соронзон хальснаас буулгав.</p>


Баталсан хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах чиглэлээр 127 уулзалт, ярилцлага, семинарыг төв, орон нутагт зохион байгуулав. Дотоод сүлжээ болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn цахим хуудаст шинээр 151 хууль, 78 тогтоолыг тайлаар оруулан өөрчлөлт хөдөлгөөнийг хийж, Тамгын газрын хууль тогтоомжийн санд Ерөнхийлөгчийн 40 зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 400 тогтоол, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 6 шийдвэрийг шинээр нэмэн оруулж, "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 48 дугаарыг хэвлэн түгээж, 200 удаа хууль тогтоомжийн лавлагаа гаргав. Улсын Их Хурлаар батлагдсан хууль тогтоомж, Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулганы үйл ажиллагааны үр дүн, цаг үеийн бусад асуудлаар нийт 80 удаа хэвлэлийн бага хурал зохион байгуулав.

Монгол Улсын Их Хурал, Монголын Парламентын бүлгэм, Улсын Их Хурлын Тамгын газрын гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэн гадаадад 10, дотоодод 11, нийт 21 айлчлал, арга хэмжээг хэрэгжүүлэв.

Тамгын газар нь Улсын Их Хурлын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн төсөв, санхүү, аж ахуй, техник хэрэгсэл, материал хангамжийн үйлчилгээг цаг тухайд нь шуурхай үзүүлж үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлсэн болно.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга

Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга



Б.Болдбаатар

Н.Ширэндэв